



**ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 12 өдөр

Дугаар A/18

Улаанбаатар хот

**Согтууруулах ундаа худалдах, түүгээр
үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.3, 15.8, 16 дугаар зүйлийн 16.1, 16.2, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 30.1, 30.2 дахь хэсэг, Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/847, 2024 оны А/219 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн Засаг даргын 2025 оны А/357 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн 2025 оны 15 дугаар хурлын тэмдэглэлийг үндэслэн спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл шинээр олгох 2 хуулийн этгээдийн жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар, спиртийн өндөр болон сул агууламжтай согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох 1 хуулийн этгээдийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Согтууруулах ундааг худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгогдсон хуулийн этгээдийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс (Б.Номин), Чингэлтэй дүүргийн Цагдаагийн газар (Т.Баатар), дүүргийн 1-24 дүгээр хорооны Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Үнэт цаасны бичилт, олголт, хураамжид байнгын хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Э.Энхсүвд)-т, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Н.Бямбагэрэл)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.МАНДУУЛ

Чингэлтэй дүүргийн Засаг даргын
2026 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн
А/18 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

СПИРТИЙН ӨНДӨР БОЛОН СУЛ АГУУЛАМЖТАЙ СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
ШИНЭЭР ОЛГОХ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН НЭРСИЙН ЖАГСААЛТ

№	Хуулийн этгээдийн нэр	Захирал	Оноосон нэр	Хуулийн этгээдийн регистр	Ангилал	Төрөл	Хороо	Хаяг, байршил
1	Премиум Нэксус ХХК	Г.Чинзориг	CU	6155804	Ая тухтай дэлгүүр	24 цаг	3	40, 50 мянгат Жуулчны гудамж 34 байр, 1 тоот
2	Дижитал Концепт ХХК	Б.Гантиг	GS 25	6531342	Ая тухтай дэлгүүр	24 цаг	19	Тахилтын 2 гудамж 203 тоот